



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүдийг батламжлах, чөлөөлөх тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсэг, 48.9.4 дэх, 48.9.12 дахь заалт, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4.13 дугаар зүйлийн 1.5 дахь, 1.18 дахь заалт, Тооллогын комиссын 2026 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүдээр дараах хуульчдын батламжилсугай. Үүнд:

1. Б.Эрхэмбаяр /прокурорын төлөөлөл/
2. Ч.Бурмаа /прокурорын төлөөлөл/
3. Б.Буянхишиг /хуульч профессорын төлөөлөл/
4. Г.Наранбаатар /хуульч профессорын төлөөлөл/
5. П.Соёл-Эрдэнэ /шүүгчийн төлөөлөл/
6. Б.Баасандорж /хуульч профессорын төлөөлөл/
7. Т.Золбоо /хуульч профессорын төлөөлөл/
8. Ц.Амарсанаа /хуульч профессорын төлөөлөл/
9. Д.Оросоо /өмгөөлөгчийн төлөөлөл/
10. М.Ванчигмаа /өмгөөлөгчийн төлөөлөл/
11. С.Ганбат /шүүгчийн төлөөлөл/

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Хуульчдын холбооны Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоол, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 17 дугаар, 21 дүгээр тогтоолоор тус тус батламжилсан Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүдийг чөлөөлж, бүрэн эрхийг дуусгавар болгосугай.

3. Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороонд хуульч профессорын төлөөллийг нэр дэвшүүлэх ажлыг нээлттэй зохион байгуулж Зөвлөлд танилцуулахыг Тамгын газар /Ш.Жолбарс/-д даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2026 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ  М.МӨНХБАТ

